



# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ

Цуврал №8

2015 оны 4 дүгээр улирлын байдлаар

## Эдийн засгийн өсөлт

Эдийн засгийн бодит өсөлт 2015 онд урьдчилсан гүйцэтгэлээр **2.3** хувьтай гарлаа.

**Хүснэгт 1. 2015 оны эхний 4 улирлын бодит ДНБ-ий өсөлт (салбаруудаар, 2010 оны үнээр)**

Бодит ДНБ		2.3%	100.0%
1	Хөдөө аж ахуй	1.3%	56.1%
2	Уул уурхай, олборлолт	2.9%	126.5%
3	Боловсруулах үйлдвэрлэл	0.1%	3.3%
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.0%	2.1%
5	Барилга	-0.1%	-2.3%
6	Бөөн/жиж.худалдаа	-0.5%	-22.3%
7	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.4%	15.3%
8	Мэдээлэл, холбоо	0.0%	2.2%
9	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.6%	25.0%
10	Бүтээгдэхүүний цэвэр татвар	-2.4%	-106.0%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Дээрх өсөлтөд уул уурхайн салбар 13.0 хувь, хөдөө аж ахуй 10.7 хувь, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 5.7 хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 2.9 хувиар өссөн нь голчлон нөлөөлжээ.


Харин бөөний болон жижиглэн худалдаа 3.6 хувь, бүтээгдэхүүний цэвэр татвар 21.1 хувь, барилга 1.4 хувиар буурсан нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлсөн байна.

**Хүснэгт 2. ДНБ-ий өсөлт (салбаруудаар, 2010 оны үнээр)**

Салбарууд		2014	2015
Бодит ДНБ		7.9%	2.3%
1	Хөдөө аж ахуй	13.7%	10.7%
2	Уул уурхай, олборлолт	19.4%	13.0%
3	Боловсруулах үйлдвэрлэл	4.2%	1.3%
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	5.3%	2.7%
5	Барилга	-4.3%	-1.4%
6	Бөөн/жиж.худалдаа	2.4%	-3.6%
7	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	14.8%	5.7%
8	Мэдээлэл, холбоо	4.7%	2.0%
9	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	10.2%	2.9%
10	Бүтээгдэхүүний цэвэр татвар	-8.1%	-21.1%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

**Дүрслэл 1. Эдийн засгийн өсөлтийн задаргаа**




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.  
Тэмдэглэл: \*2015 оны урьдчилсан гүйцэтгэл

## Инфляци

Хэрэглээний үнийн улсын индекс 12 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс **1.9** хувиар, Улаанбаатар хотын индекс **1.1** хувиар тус тус өсөв.

**Дүрслэл 2. Инфляцийн задаргаа**




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

Улаанбаатар хотын 12 дугаар сарын жилийн инфляцийг бүтцээр нь задлан авч үзвэл -235.5 хувийг (-2.7 нэгж хувь) мах, махан бүтээгдэхүүн, 46.6 хувийг (0.5 нэгж хувь) махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн, 23.9 хувийг (0.3 нэгж хувь) хувцас, 40.8 хувийг (0.5 нэгж хувь) орон сууц, ус, түлш, цахилгааны үнийн өсөлт бүрдүүлсэн бол үлдсэн 224.1 хувийг (2.5 нэгж хувь) бусад бараа, үйлчилгээний үнийн өсөлт бий болгосон байна.

Нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамт үнэ тогтворжуулах хөтөлбөрийн нөлөөгөөр үргэлжлэн буурч байгаа бол импортын барааны инфляци алгуур саарч байна. Инфляци зорилтот түвшинтэйгээ нийцтэй болж буурч буй нь инфляцид нөлөөлөх ханшийн нөлөөлөл буурсаар байгаатай холбоотой юм.

**Дүрслэл 3. Инфляцийн задаргаа**




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

### Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл 2015 оны эхний 12 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 268.1 сая ам.долларын алдагдалтай гарсан байна. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл 479.2 сая ам.долларын ашигтай, харин урсгал данс 547.9 сая ам.долларын алдагдалтай гарав.


Дүрслэл 4. Төлбөрийн тэнцэл



Эх сурвалж: Монголбанк.  
Тэмдэглэл: \*2015 оны урьдчилсан гүйцэтгэл.

Урсгал дансны алдагдлын ДНБ-д эзлэх хувь 2015 оны эхний 12 сарын урьдчилсан гүйцэтгэлээр -4.7 хувь болоод байна.

Дүрслэл 5. Урсгал тэнцлийн бүтэц




Эх сурвалж: Монголбанк.  
Тэмдэглэл: \*2015 оны урьдчилсан гүйцэтгэл.

Төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал 2015 оны эхний 12 сард өмнөх оны мөн үеэс 61.0 хувиар буурч 547.9 сая ам.долларт хүрчээ.

Барааны гадаад худалдааны ашиг 24.3 хувиар өсч, 1235.1 сая ам.долларт хүрсэн, үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 43.0 хувиар буурч, 885.0 сая ам.долларт хүрсэн зэрэг нь урсгал тэнцэл ийнхүү сайжрах суурь нөхцөл болов.


Дүрслэл 6. Урсгал тэнцлийн санхүүжилт



Эх сурвалж: Монголбанк.  
Тэмдэглэл: \*2015 оны урьдчилсан гүйцэтгэл.


Хөрөнгө, санхүүгийн дансны ашиг тайлант хугацаанд 54.9 хувиар буурч, 479.2 сая ам.долларт хүрчээ. 2013 оны 10 дугаар сард хөрөнгө оруулалтын урт хугацааны тогтвортой орчинг бүрдүүлэх багц хуулийг УИХ-аас баталсан хэдий ч, Монгол Улсад орох гадаадын шууд хөрөнгө оруулалт 2015 оны эхний 12 сард өмнөх оноос 20.5 хувиар буюу 56.6 сая ам.доллараар буурав.

Дүрслэл 7. Хөрөнгө, санхүүгийн дансны бүтэц




Эх сурвалж: Монголбанк.  
Тэмдэглэл: \*2015 оны урьдчилсан гүйцэтгэл.

Дүрслэл 8. Гадаадын шууд хөрөнгө оруулалт (сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк.  
Тэмдэглэл: \*ДНБ-ий 2015 оны 4 дүгээр улирлын урьдчилсан гүйцэтгэл ашиглав.

**Дүрслэл 9. Гадаад худалдааны тэнцэл (с.и.ф нөхцөлөөр, сая ам.доллар)**



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар.

### Гадаад валютын улсын нөөц (ГВУН)

ГВУН 2015 оны 12 дугаар сарын байдлаар өмнөх оноос 19.8 хувиар буюу 326.8 сая ам.доллараар буурч **1323.1** сая ам.долларт хүрлээ.

Валютын төлбөртэй импортын дүн буурснаар импортын хэрэгцээг хангах ГВУН-ийн түвшин 5.0 сард хүрсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 0.5 нэгжээр илүү байна.

**Дүрслэл 10. Гадаад валютын улсын нөөц**



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Импортын хэрэгцээг хангах түвшинг ГВУН-ийг валютын төлбөртэй импортын сүүлийн 3 сарын дундаж үзүүлэлтэд харьцуулж тооцов.

### Гадаад худалдааны нөхцөл

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс (2012 оны суурьтай) 2015 оны 12 дугаар сард **1.17**-д хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **26.4** хувиар буурав.

Гадаад худалдааны нөхцөлийн индекс буурахад экспортын үнэ импортын үнийн индексээс илүү хурдацтай буурсан нь нөлөөлжээ.

**Дүрслэл 11. Гадаад худалдааны нөхцөлийн индекс**




Эх сурвалж: Монголбанк.

### Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш 2013, 2014 оны мөн үед харгалзан 19.9, 12.4 хувиар тус тус суларч байсан бол 2015 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс **6.0** хувиар суларч, **1995.8** төгрөгт хүрээд байна.

Харин гадаад худалдааны голлох түнш орнуудын валютын ханштай харьцуулсан нэрлэсэн үйлчилж буй ханш (NEER) **1.1** хувиар чангарч, инфляцийн зөрүүг оруулан тооцсон бодит үйлчилж буй ханш (REER) **0.1** хувиар суларсан байна.

**Дүрслэл 12. Гадаад валютын ханш (жилийн өсөлтийн хувь)**



Эх сурвалж: Монголбанк.

## Улсын төсөв

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого ба тусламжийн дүн 2015 оны эхний 12 сарын байдлаар **5976.1** тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн **7137.9** тэрбум төгрөгт хүрч, тэнцвэржүүлсэн төсвийн тэнцэл **1163.2** тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

Нэгдсэн төсвийн орлогын тасралтад НӨАТ **161.5** тэрбум төгрөг, онцгой албан татвар **52.0** тэрбум төгрөг, хувь хүний орлогын албан татвар **25.6** тэрбум төгрөг, татварын бус орлого **144.3** тэрбум төгрөгөөр тус тус тасарсан нь голлон нөлөөлжээ.

### Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө ба гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Нэгдсэн төсвийн орлого	Жилийн төлөвлөгөө	2015 оны эцэс			
		*	**	**/*	***
Нийт орлого ба тусламжийн дүн	6 076	6 076	5 976	98%	-3%
Тогтворжуулалтын сан	2	2	2	100%	-103%
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	6 074	6 074	5 974	98%	-4%
<i>I. Татварын орлого</i>	<i>5 099</i>	<i>5 099</i>	<i>5 143</i>	<i>101%</i>	<i>-1%</i>
1. Орлогын албан татвар	1 014	1 014	1 179	116%	7%
1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	519	519	699	135%	12%
1.2. Хувь хүний орлогын албан татвар	537	537	512	95%	7%
2. Нийгмийн даатгалын орлого	1 049	1 049	1 039	99%	7%
3. Хөрөнгийн албан татвар	83	83	86	104%	73%
4. Дотоодын бараа, үйлчилгээний татвар	1 854	1 854	1 641	89%	-12%
4.1. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1 199	1 199	1 037	87%	-24%
4.2. Онцгой албан татвар	644	644	592	92%	30%
4.3. Тусгай зориулалтын орлого	11	11	12	107%	-70%
5. Гадаад үйл ажиллагааны орлого	329	329	321	97%	-10%
6. Бусад татвар, төлбөр, хураамж	769	769	877	114%	1%
<i>II. Татварын бус орлого</i>	<i>975</i>	<i>975</i>	<i>831</i>	<i>85%</i>	<i>-7%</i>
1. Хөрөнгийн орлого	69	69	55	79%	-
2. Тусламжийн орлого	63	63	39	63%	-

Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: \*Төлөвлөгөө, \*\*Урьдчилсан гүйцэтгэл, \*\*\*Жилийн өсөлтийн хувь.

Төсвийн зарлага ба цэвэр зээлийн гүйцэтгэл өмнөх оны мөн үеэс **1.5** хувиар буюу **105.6** тэрбум төгрөгөөр өсч **7137.9** тэрбум төгрөгт хүрч, **98.4** хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

### Хүснэгт 4. Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө ба гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Нэгдсэн төсвийн зарлага	Жилийн төлөвлөгөө	2015 оны эцэс			
		*	**	**/*	***
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	7 253	7 253	7 137	98%	2%
Урсгал зардал	5 773	5 773	5 750	100%	10%
1. Бараа, үйлчилгээний зардал	2 775	2 775	2 821	102%	9%
1.1. Цалин хөлс	1 727	1 727	1 706	99%	9%
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	161	161	158	98%	7%
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	887	887	958	108%	8%
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	731	731	731	100%	46%
3. Татаас ба шилжүүлэг	2 267	2 267	2 198	97%	3%
Хөрөнгийн зардал	1 531	1 531	1 338	87%	-23%
1. Дотоод эх үүсвэрээр:	1 356	1 356	1 131	83%	-25%
2. Гадаад эх үүсвэрээр:	174	174	207	119%	-12%
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-98	-98	6	-6%	-91%
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-1 179	-1 179	-1 163	99%	44%


Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: \*Төлөвлөгөө, \*\*Урьдчилсан гүйцэтгэл, \*\*\*Жилийн өсөлтийн хувь.

Төсвийн урсгал зардал өмнөх оны мөн үеэс 10.0 хувь буюу 523.3 тэрбум төгрөгөөр өсч **5750.9** тэрбум төгрөгт, хөрөнгийн зардал 23.1 хувиар буюу 401.9 тэрбум төгрөгөөр буурч **1339.0** тэрбум төгрөгт, эргэж төлөгдөх цэвэр зээл 91.3 хувиар буюу 59.3 тэрбум төгрөгөөр буурч **5.6** тэрбум төгрөгт тус тус хүрчээ.

2015 оны эхний 12 сарын байдлаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл **-1163.2** тэрбум төгрөг байгаа нь ДНБ-ий **-5.0** хувьтай тэнцэж байна.

### Дүрслэл 13. Нэгдсэн төсвийн тэнцэл




Эх сурвалж: Сангийн яам.

## Мөнгө, санхүүгийн үзүүлэлтүүд

M2 мөнгийг актив талаас нь авч үзэхэд 2015 оны 12 дугаар сарын байдлаар дотоод цэвэр авлага өмнөх оны мөн үеэс **5.6** хувиар буюу **790.3** тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

### Дүрслэл 14. M2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа (актив тал)



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \*ОСИСТБ хөтөлбөрийн зээлийн нөлөөллийг хасч тооцсон дүн болно.


Харин гадаад цэвэр актив 2015 оны 12 дугаар сарын байдлаар **-3.9** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2.2 их наяд төгрөгөөр буурчээ. Дотоод цэвэр актив гадаад цэвэр активын бууралтыг нөхөхүйц хэмжээнд хүрч өсөөгүй тул M2 мөнгөний жилийн өсөлт **-5.5** хувьтай буюу бууралттай гарлаа.

Пассив талаас нь авч үзвэл M2 мөнгөний өсөлтийн 0.2 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, -0.2 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, -4.3 нэгж хувийг гадаад валютын харилцах, -1.2 нэгж хувийг M1 мөнгөний бууралт тус тус тайлбарлаж байна.

2014 оны эцэст мөнгөний нийлүүлэлтийн **-16.0** хувийг эзэлж байсан гадаад цэвэр актив 2015 оны эцсийн байдлаар **-38.9** хувьд хүрч буурчээ. Ийнхүү M2


мөнгөний нийлүүлэлт дэх гадаад цэвэр активын огцом бууралтыг бий болгосон гол хүчин зүйл нь 2012 оноос эхтэй төлбөрийн тэнцлийн хүндрэл юм.

Дүрслэл 15. M2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа (пассив тал)



Эх сурвалж: Монголбанк.

Дүрслэл 16. Мөнгөний үзүүлэлтүүдийн ерөнхий бүтэц ба хандлага




Эх сурвалж: Монголбанк.

## Банкны салбарын зарим үзүүлэлтүүд

2013 оны эхний хагас хүртэл тогтмол буурч байсан чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2015 оны 4 дүгээр улиралд 7.1 хувь болж өмнөх оны мөн үеэс 2.1 нэгж хувиар өсөв.

Дүрслэл 17. Чанаргүй зээлийн харьцаа (салбараар)




Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \*Татан буугдсан банкуудыг хасч тооцов.

Чанаргүй зээлийн харьцаа уул уурхайн салбарт 24.4 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбарт 12.0 хувьтай байгаа нь дунджаас өндөр байгаа юм. Харин Анод, Зоос, Хадгаламж банкуудыг хасч тооцвол дээрх харьцаа 5.5 хувьтай байв.

Дүрслэл 18. Зээлийн өсөлтийн задаргаа, чанаргүй зээлийн харьцаа



Эх сурвалж: Монголбанк.


Тэмдэглэл: \*ОСИСТБ хөтөлбөрийн зээлийн нөлөөллийг хасч тооцсон дүн болно.

2015 оны 4 дүгээр улирлын байдлаар хадгаламжийн байгууллагуудын зээлийн өрийн үлдэгдэл 11.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.5 хувиар буурав. Энэ бууралтын -1.7 нэгж хувийг аж ахуйн нэгжид олгосон зээл, -5.5 нэгж хувийг иргэдийн зээл, үлдсэн 0.7 нэгж хувийг бусад салбар эзэлж байна.

Чанаргүй зээл ба нийт зээлийн харьцаа иргэдийн зээлийн хувьд 2010 оноос хойш тогтмол буурсаар 2014 оны 6 дугаар сард 0.9 хувьд хүрч байсан бол энэ оны эцэст 2.6 хувьд хүрч өсөв.



Дүрслэл 19. Иргэдийн зээлийн жилийн өсөлт




Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \*Жижиг дунд үйлдвэрлэл.

Нийт зээлийн **43.0** хувийг эзэлж буй иргэдийн зээл 2015 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс **12.1** хувиар буурчээ.

Дүрслэл 20. Иргэдийн зээлийн бүтэц (2015 оны 4 дүгээр улирлын байдлаар)




Эх сурвалж: Монголбанк

Тэмдэглэл: \*Жижиг дунд үйлдвэрлэл.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт банкны системийн хэмжээгээр 2015 оны 4 дүгээр улиралд 17.9 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар өсчээ. Энэ нь Монголбанкнаас тогтоосон шаардлагаас 5.9 нэгж хувиар өндөр үзүүлэлт юм.

Дүрслэл 21. Өөрийн хөрөнгө




Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \*Өөрийн хөрөнгө.

Харин төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт банкны системийн хэмжээгээр 2015 оны 4 дүгээр улиралд 39.7 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.5 нэгж хувиар буурчээ. Энэ нь Монголбанкнаас тогтоосон шаардлагаас 14.7 нэгж хувиар өндөр байна.

Дүрслэл 22. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \*Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар.

Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү тайлант хугацааны эцэст өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар өсч, хадгаламжийн бодит хүү эерэг 11.4 хувьд хүрээд байна.


Дүрслэл 23. Банкны хадгаламж, зээлийн хүү



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \*Хөтөлбөрийн зээлийг оруулсан болно.

Дүрслэл 24. Хүүний динамик



Эх сурвалж: Монголбанк.